БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/121/НА-СТА-ТШ3**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2022 он

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ........ 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 9
3. Аудитын тайлан........ 10
3.1 Ерөнхий зүйл........ 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10
3.4 Материаллаг байдал ........ 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 12
3.8 Аудитын гол асуудал ........ 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........ 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 14
4.1 Төлбөрийн акт........ 14
4.2 Албан шаардлага ........ **Error! Bookmark not defined.**
4.2 Зөвлөмж ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,212,349.50** | **40,625,643.03** |
| **33** | **АВЛАГА** | 1,260,000.00 | 1,470,810.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 210,810.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,260,000.00 | 1,260,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,260,000.00 | 1,260,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 62,952,349.50 | 39,154,833.03 |
| **351** | **Түүхий эд материал** | 12,153,275.00 | 12,561,525.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,153,275.00 | 12,561,525.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 50,799,074.50 | 26,593,308.03 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 999,600.00 | 100,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,506,105.00 | 7,077,280.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 310,000.00 | 310,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 3,080,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 220,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,983,369.50 | 15,805,528.03 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **849,036,994.75** | **800,975,137.09** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 849,036,994.75 | 800,975,137.09 |
| **392** | **Биет хөрөнгө** | 839,930,794.75 | 791,868,937.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 781,556,683.00 | 781,556,683.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -170,294,105.82 | -207,000,483.54 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 174,534,800.00 | 174,534,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -87,964,022.58 | -109,381,792.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 187,188,956.00 | 200,430,456.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -151,926,346.96 | -163,918,098.49 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 47,686,210.50 | 51,476,210.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -25,882,368.65 | -29,672,203.24 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 131,344,720.00 | 155,903,273.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -46,313,730.74 | -62,059,908.14 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 9,106,200.00 | 9,106,200.00 |
| 39301 | Програм хангамж | 230,000.00 | 230,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -230,000.00 | -230,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,106,200.00 | 9,106,200.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **913,249,344.25** | **841,600,780.12** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **455,241.92** | **474.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 455,241.92 | 474.00 |
| **413** | **Өглөг** | 455,241.92 | 474.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 433,241.92 | 474.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 22,000.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 22,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **912,794,102.33** | **841,600,306.12** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 912,794,102.33 | 841,600,306.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 302,128,037.00 | 302,128,037.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 302,128,037.00 | 302,128,037.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 595,100,169.37 | 523,906,373.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 595,100,169.37 | 595,100,169.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -71,193,796.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 15,565,895.96 | 15,565,895.96 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **913,249,344.25** | **841,600,780.12** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **812,046,607.00** | **542,627,120.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **342,211,895.00** | **57,685,053.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 342,211,895.00 | 57,685,053.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 342,211,895.00 | 57,685,053.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 342,211,895.00 | 56,685,053.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **469,834,712.00** | **484,942,067.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,040,012.00 | 41,250,267.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,040,012.00 | 21,798,073.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 19,452,194.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 422,794,700.00 | 443,691,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 422,794,700.00 | 443,691,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **533,990,916.75** | **610,340,916.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **524,815,270.86** | **610,340,916.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 458,291,307.63 | 563,936,919.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 232,184,041.94 | 214,051,799.02 |
| 210101 | Үндсэн цалин | 232,184,041.94 | 214,051,799.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,372,500.75 | 29,529,629.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,568,398.75 | 29,529,629.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,675,602.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,900,900.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 475,200.00 | 00.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,752,400.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,343,500.00 | 24,379,946.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,889,800.00 | 3,104,850.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,453,700.00 | 21,275,096.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,241,998.00 | 58,580,668.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,500,400.00 | 5,587,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,015,148.00 | 24,034,732.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,610,000.00 | 575,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 98,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 7,797,431.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 116,450.00 | 732,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 19,755,805.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,122,050.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,090,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,032,050.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 316,000.00 | 10,171,581.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 316,000.00 | 9,971,581.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,953,000.00 | 3,048,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,953,000.00 | 3,048,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36,040,600.00 | 84,849,333.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 33,036,281.00 | 80,293,333.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215,775.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 409,544.00 | 320,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 172,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,079,000.00 | 3,564,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 94,717,616.94 | 139,325,962.63 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,864,500.00 | 48,674,051.97 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 1,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 85,853,116.94 | 89,651,910.66 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 66,523,963.23 | 46,403,996.92 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,400,000.00 | 26,881,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 25,481,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,400,000.00 | 1,400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,126,694.00 | 9,608,958.00 |
| 213304 | Хөрөнгийн | 1,126,694.00 | 9,608,958.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 54,997,269.23 | 9,913,238.92 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,997,269.23 | 9,913,238.92 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,175,645.89** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,175,645.89 | 00.00 |
| 220001 | Барилга байгууламж | 9,175,645.89 | 00.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **278,055,690.25** | **-67,713,796.21** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 3,480,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 3,480,000.00 |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -3,480,000.00 |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **278,055,690.25** | **-71,193,796.21** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **469,834,712.00** | **485,942,067.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **1,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 1,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 1,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **469,834,712.00** | **484,942,067.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,040,012.00 | 41,250,267.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,040,012.00 | 21,798,073.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 19,452,194.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 422,794,700.00 | 443,691,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 422,794,700.00 | 443,691,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **461,506,712.00** | **464,792,067.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **461,506,712.00** | **464,792,067.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **394,982,748.77** | **418,388,070.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 217,670,035.77 | 212,597,364.08 |
| 210101 | Үндсэн цалин | 204,414,725.77 | 196,595,955.97 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,255,310.00 | 16,001,408.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,561,900.00 | 29,612,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,955,898.00 | 20,838,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,477,502.00 | 2,193,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,900,900.00 | 1,754,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 475,200.00 | 438,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,752,400.00 | 4,387,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,843,500.00 | 24,379,946.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,889,800.00 | 3,104,850.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,953,700.00 | 21,275,096.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,873,500.00 | 32,814,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,567,900.00 | 4,375,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,683,600.00 | 17,389,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,422,000.00 | 600,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 394,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 360,000.00 | 9,320,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 840,000.00 | 735,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,400,400.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,400,400.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 725,000.00 | 14,221,581.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 4,050,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 167,000.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 558,000.00 | 9,971,581.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,953,000.00 | 3,048,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,953,000.00 | 3,048,000.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 62,210,313.00 | 36,974,807.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 58,070,129.00 | 32,418,807.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 320,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,184.00 | 172,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,267,000.00 | 3,564,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,745,100.00 | 64,739,572.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,745,500.00 | 63,739,572.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 999,600.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **66523963.23** | **46403996.92** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,400,000.00 | 26,881,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 25,481,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,400,000.00 | 1,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 56,123,963.23 | 19,522,196.92 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,997,269.23 | 9,913,238.92 |
| 213405 | Хөрөнгийн | 1,126,694.00 | 9,608,958.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,328,000.00** | **21,150,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,328,000.00** | **21,150,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,328,000.00** | **21,150,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,328,000.00 | 21,150,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,328,000.00 | 21,150,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,328,000.00** | **-21,150,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 302,128,037.00 | 17,485,895.96 | 278,906,861.48 | 598,520,794.44 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **302,128,037.00** | **17,485,895.96** | **278,906,861.48** | 598,520,794.44 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 54,435,883.31 | 54,435,883.31 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **595,100,169.37** | 912,794,102.33 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **595,100,169.37** | 912,794,102.33 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **595,100,169.37** | 912,794,102.33 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -71,193,796.21 | -71,193,796.21 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **302,128,037.00** | **15,565,895.96** | **523,906,373.16** | 841,600,306.12 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 444,691,800.00 | 434,778,561.08 | 9913238.92 | 97.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 444,691,800.00 | 434,778,561.08 | 9913238.92 | 97.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 417,810,000.00 | 407,896,761.08 | 9913238.92 | 97.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 219,348,700.00 | 212,597,364.08 | 6751335.92 | 96.9 |
| 210101 | Үндсэн цалин | 202,163,400.00 | 196,595,955.97 | 5567444.03 | 97.2 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,185,300.00 | 16,001,408.11 | 1183891.89 | 93.1 |

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,612,200.00 | 29,612,200.00 | 0.00 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,838,200.00 | 20,838,200.00 | 0.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,193,500.00 | 2,193,500.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,754,800.00 | 1,754,800.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 438,700.00 | 438,700.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,387,000.00 | 4,387,000.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,249,400.00 | 24,379,946.00 | 869454.00 | 96.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,800,800.00 | 3,104,850.00 | 695950.00 | 81.7 |
| 210302 | Түлш, халаалт | 21,448,600.00 | 21,275,096.00 | 173504.00 | 99.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,042,900.00 | 32,814,600.00 | 228300.00 | 99.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,375,400.00 | 4,375,400.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,389,500.00 | 17,389,500.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 678,000.00 | 600,000.00 | 78000.00 | 88.5 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000.00 | 394,700.00 | 5300.00 | 98.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,360,000.00 | 9,320,000.00 | 40000.00 | 99.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 840,000.00 | 735,000.00 | 105000.00 | 87.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35,072,900.00 | 35,071,581.00 | 1319.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,500,000.00 | 14,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210602 | Тавилга | 10,000,000.00 | 10,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 10,372,900.00 | 10,371,581.00 | 1319.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,703,500.00 | 3,048,000.00 | 1655500.00 | 64.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,703,500.00 | 3,048,000.00 | 1655500.00 | 64.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,574,000.00 | 5,333,498.00 | 240502.00 | 95.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,000.00 | 777,498.00 | 222502.00 | 77.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 338,000.00 | 320,000.00 | 18000.00 | 94.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 172,000.00 | 172,000.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 65206400.00 | 65039572.00 | 166828.00 | 99.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,206,400.00 | 64,039,572.00 | 166828.00 | 99.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26881800.00 | 26881800.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,881,800.00 | 26,881,800.00 | 0.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,481,800.00 | 25,481,800.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400,000.00 | 1,400,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 444,691,800.00 | 389,694,530.77 | 54997269.23 | 87.6 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 443,691,800.00 | 388,694,530.77 | 54997269.23 | 0.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 443,691,800.00 | 388,694,530.77 | 54997269.23 | 0.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 28.00 | 28.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21.00 | 21.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **46255712.00** | **41,250,267.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **46255712.00** | **41,250,267.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 45129018.00 | 31,641,309.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 45129018.00 | 31,641,309.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45129018.00 | 31,641,309.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1126694.00** | **9,608,958.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 1126694.00 | 9,608,958.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 46255712.00 | 41250267.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 46,255,712.00 | 41,250,267.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 46255712.00 | 21,798,073.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 19,452,194.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг дарга Д.Цэнд-Аюуш, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Нямдорж нар зурсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг хүлээж биш хүрч үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 536,412.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,046.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 5,230.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 5,950.8 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,648.6 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 64,212.3 | 40,625.6 | (23,586.7) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,260.0 | 1,470.8 | 210.8 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 62,952.3 | 39,154.8 | (23,797.5) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 849,037.0 | 800,975.1 | (48,061.9) |
| Үндсэн хөрөнгө | 1,331,647.6 | 1,373,237.6 | 41,590.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | (482,610.6) | (572,262.5) | (89,651.9) |
| **Нийт хөрөнгө** | **913,249.3** | **841,600.8** | **(71,648.6)** |
| Өр төлбөр | 455.2 | 0.5 | (454.8) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 912,794.1 | 841,600.3 | (71,193.8) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **913,249.3** | **841,600.8** | **(71,648.6)** |

Авлагын дансны үлдэгдэл 210.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2020 оны 04 дүгээр сард 1260.0 мянган төгрөг зарцуулж тэмцээний медаль, цом, өргөмжлөл, мандат зэргийг худалдан авсан ч Covid-19 цар тахлын улмаас тэмцээн хойшлогдсонтой холбоотой авлагаар бүртгэсэн өмнөх оны авлага барагдаагүй байгаа бол тайлант онд ажиллагсадтай холбоотой хувь хүний орлогын албан татварын 210.8 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,154.8 мянган төгрөг болж 23,797.5 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй 19,755.8 мянган төгрөгийн хөрөнгийн байгууллагын даргын тушаалаар акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,373,237.6 мянган төгрөг болж өмнөх оноос 41,590.1 мянган төгрөгөөр өссөн нь 21,150.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 115 дугаар тогтоолоор 2,381.5 мянган төгрөгийн малын гарал үүслийн гэрчилгээний систем нэвтрүүлэх тоног төхөөрөмж, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 18,058.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 841,600.3 мянган төгрөг болж 71,193.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 71,193.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 555,075.8 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 555,075.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 164,378.9 мянган төгрөгөөр бууруулж 390,696.9 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг 444,691.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 443,691.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 434,778.6 мянган төгрөгийг зарцуулж 9,913.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 434,778.6 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшлын зардлыг 6,751.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 869.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 228.3 мянга, томилолтын зардлыг 1,655.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах алдаа, зөрчил илэрсэн ба тус алдаа, зөрчлүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар арилгаж нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандартын дагуу бүртгэсэн байна.

- Санхүүгийн тайланд тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал дансдад 32792.1 мянган төгрөгийн өвс тэжээлийн үлдэгдэл

байгаа бүртгэл байгаа боловч эд хариуцагчийн тайланд 3016.5 мянган төгрөгийн өвсний үлдэгдэл байгаа нь 29775.6 мянган төгрөгөөр зөрүүтэй.

- Нягтлан бодогч санхүүгийн программд бүртгэл хөтлөхдөө өглөг, авлагын дансаар дамжуулан тооцоо үүсгэн бүртгээгүйгээс санхүүгийн тайланд хасах дүнтэй 115897.5 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүссэн.
- Санхүүгийн тайланд тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал дансанд 32792.1 мянган төгрөгийн өвс тэжээлийн үлдэгдэл байгаа бүртгэл байгаа боловч эд хариуцагчийн тайланд 3016.5 мянган төгрөгийн өвсний үлдэгдэл байгаа нь 29775.6 мянган төгрөгөөр зөрүүтэй зэрэг алдаа, зөрчил илэрсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд нийт 95 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 610,340.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 76,350.0 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 782,138.0 мянган төгрөгийн 151 мэдээллээс 126 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 25 мэдээлэл хугацаа

хоцроож мэдээлсэн ба 5 сая төгрөгөөс үнийн дүн бүхий худалдан авалт, зарлагын гүйлгээтэй холбоотой 101,156.8 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 390,696.9 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 53,994.9 мянган төгрөг нэмж 443,691.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 434,778.6 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 2.2 хувийн хэмнэлт гаргасан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 141,736.0 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 53,994.9 мянган төгрөг нэмж 195,730.9 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 192,569.0 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 1.6 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 4,375.4 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,375.4 мянган төгрөг зарцуулсан байна.

-Албан томилолтын зардлыг 4,903.5 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 3,048.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 37.8 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 25,249.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 24,379.9 мянган төгрөг зарцуулж баталсан дүнгээс 869,.4 мянган төгрөг буюу 3.4 хувь хэмнэсэн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 102601.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 6160.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 95441.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 442.3 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 442.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй мэдээллийг нөхөн мэдээлэх, Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах 2 албан шаардлага өглөө.

### 4.1 Төлбөрийн акт

1. Цалингаас 08, 09 дүгээр саруудад 231.5 мянган төгрөгийн цалинг нэг албан хаагчид илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил,

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнаар 231.5 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Цалингийн зардлаас ажилчдаас суутгасан ХХОАТ-ыг 210.8 мянган төгрөгөөр илүү шилжүүлж авлагаар бүртгэж төсөвт зардлыг хэтрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс илүү төлсөн 210.8 мянган төгрөгийг суутган тооцож төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

**4.2 Албан шаардлага**

1. Тайлант хугацаанд оруулбал зохих 782,138.0 мянган төгрөгийн 151 мэдээллээс 126 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 25 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн ба 5 сая төгрөгөөс үнийн дүн бүхий худалдан авалт, зарлагын гүйлгээтэй холбоотой 101,156.8 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 7 хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Байгууллагын 2021 оны төсвийг 555,771.4 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 49,566.8 мянган төгрөг нэмж 525,782.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 79,555.4 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 567,020.3 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 6.3 хувийн хэмнэлт гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар | 4 | 442.3 | | | 2 | 442.3 | 2 | - | - | - |

______oOo______